



**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

**“БАЯН-ӨНДӨР, ЖАРГАЛАНТ СУМЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ
САНГИЙН 2019-2020 ОНЫ ЗЭЭЛИЙН ОЛГОЛТ ҮР ДҮН”
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ**

ОРА-2021/91-ШТА-ГА



**САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХДАА ЖУРАМ, ЗААВРЫГ БҮРЭН
ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

**Орхон аймаг
2021 он**



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 4/18


Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов эрх үүргийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Баян-өндөр, Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зээлийн олголт үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэн, Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаяр нарт хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 2 дугаар улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /Б.Буян-Ундрах/, аудитор /Д.Цогбадрах/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	1
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл, үндсэн мэдээлэл.	2
Аудитын менежер: Б.Эрдэнэ	Бүлэг 1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу үр дүнтэй зарцуулаагүй байна.	4
Ахлах аудитор: Б.Буян-Ундрах	1.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу төлөвлөх шаардлагатай байна.	4
Аудитор: Д.Цогбадрах	1.2 Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй байна.	5
2021 оны 12 дугаар сар	1.3 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүй байна.	7
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	1.4 Зээлийн гэрээний хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.	8
Уг тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү. www.audit.mn	Бүлэг 2. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй хэдий ч өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.	10
Хаяг: Орхон аймаг дахь төрийн аудитын газар	2.1 Сумдын ИТХ-аас томилсон орон тооны бус хяналтын зөвлөлүүд журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.	10
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	2.2 Сангийн зарцуулалтад хийсэн аудитаар өмнөх онуудад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.	10
	Аудитын дүгнэлт	11
	Аудитын зөвлөмж	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
СХХ	Сум хөгжүүлэх сан

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2021 оны А/28 тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөний дагуу, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийгдсэн. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх.
- Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөтэй хэрэгжиж, өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад сумдын сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд Орхон аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС-300, 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан сумдын Засаг дарга болон бусад холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан. /Асуудлын шинжилгээг (Хавсралт №2)-д, арга зүйг (Хавсралт №3)-д, материаллаг байдлын түвшнийг (Хавсралт №4)-д үзүүлэв./

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудиттай холбоотой дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгоно. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоол
- Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Д.Цогбадрах нар хийж гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 15-нд эхэлж, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хийж гүйцэтгэнэ. Аудитын тайланг сумдын Засаг дарга нарт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Үндсэн мэдээлэл:

ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” журмыг баталсан байна.

Уг тогтоолоор ЗГ-ын 2011 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай” 134 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцжээ. СХС-ийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулахаар журамлагдсан.

БҮЛЭГ 1. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.**1.5 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу төлөвлөх шаардлагатай байна.**

СХС-ийн хөрөнгийн эх үүсвэр нь улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө, сангаас олгосон зээлийн хүүгийн орлого, хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги зэргээс бүрдэж байна. Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.8-д “Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна.”, 3.3-д “Сангийн үйл ажиллагааны талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.”, 3.3.1-д “Сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох.”, 3.5.7-д “сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах,” гэж тус тус заажээ.

Аудитаар сумдын 2019, 2020 оны ИТХ-аас баталсан төсөв, төсвийн гүйцэтгэлийг харьцуулахад **Жаргалант сумын хувьд:**

/Мян.төг/

Үзүүлэлт	2019 он				2020 он			
	Төлөвлөгөө /ИТХ/	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө /ИТХ/	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Үндсэн зээлийн эргэн төлөлт	175,620.0	74,511.9	101,108.1	42%	184,275.7	69,827.0	114,448.7	38%
Зээлийн хүүгийн орлого	5,432.6	4,181.2	1,251.4	77%	4,372.7	5,040.3	(667.6)	115%
Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги, торгууль	-	24.3	(24.3)		-	-	-	
Нийт	181,052.60	78,717.40	102,335.20	43%	188,648.40	74,867.30	113,781.10	40%

СХС-ийн хөрөнгийн орлогыг төлөвлөхдөө үндсэн зээл, хүүгийн орлогыг салгаж төлөвлөсөн хэдий ч зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, хяналтын зардлыг бодитой төлөвлөөгүй байна.

2020 онд зээлийн хүүгийн орлогын гүйцэтгэл 115 хувь байгаа нь цар тахлын үед зээлдэгч нар 6 сарын хугацаанд зөвхөн зээлийн хүүг төлж байсантай холбоотой байна.

Жаргалант сумын СХС-ийн орлогын эх үүсвэр болох зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төвлөрүүлэлт 2019 онд 43.0 хувь, 2020 онд 40 хувьтай байгаа нь ажил

хариуцсан холбогдох албан тушаалтнууд зээл олголтод хайнга хариуцлагагүй хандсан, зээлийн ашиглалтын явцад хяналт тавьдаггүйтэй холбоотой байна.

Баян-Өндөр сумын хувьд:

СХС-ийн хөрөнгийн орлогыг үндсэн зээл, хүүгийн орлогыг салгаж төлөвлөөгүй зөвхөн зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, хяналтын зардлыг төлөвлөсөн байна.

Баян-Өндөр сумын СХС-ийн орлогын эх үүсвэр болох зээлийн үндсэн төлбөр, хүүгийн орлогыг төлөвлөхгүй байгаа нь Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.1¹ дэх заалтыг зөрчсөн байна.

1.6 Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй байна.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Баян-Өндөр, Жаргалант сумдын Засаг даргаар ахлуулан, ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулсан байна.

Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн ИНХ-аар хэлэлцэн сонгосон байхаар журамд заасан. Гэтэл Баян-Өндөр, Жаргалант сумдын зарим зөвлөлийн гишүүдийг багийн ИНХ-аар хэлэлцүүлдэггүй сумын ИТХ-ын тогтоолоор томилсон байна.

СХС-гийн хөрөнгөөр төсөл арга хэмжээний төсөл сонгон шалгаруулалтыг ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолын дагуу зээл олгох төслийн 6 шалгуур үзүүлэлтийг, зээлдэгчид тавигдах 4 шаардлагын дагуу сонгон шалгаруулалтыг хийхээр заажээ.

СХС-ийн хөрөнгөнөөс 2019, 2020 онуудад зээл авсан иргэний төсөл сонгон шалгаруулалт, гэрээ, бусад баримт бичигтэй танилцаж үзэхэд:

1. Баян-Өндөр сумын СХС-аас хүлэмжийн аж ахуйн зориулалтаар болон эко ногоон ургамлын үйлдвэрийн зориулалтаар зээл авсан 2 иргэний хамтран зээлдэгч 1 хүн байна.
2. Баян-Өндөр сумын СХС-аас хамаарал бүхий 3 иргэнд 2019 оны дугаар 18/441, 2020 оны дугаар 220/462, дугаар 2020/461 гэрээнүүдээр нийт 30.0 сая төгрөгийн зээл олгосон.

¹ сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох;

3. Баян-Өндөр сумын СХС-аас Орхон аймгийн Жаргалант суманд бүртгэлтэй 2 иргэнд 2019, 2020 онуудад нийт 20.0 сая төгрөгийн зээл олгосон.
4. Баян-Өндөр сумын СХС-аас зээлийн барьцаанд 2019 онд 2, 2020 онд 2 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд авч иргэн, аж ахуй нэгжүүдэд нийт 50.0 сая төгрөгийн зээл олгосон.
5. Баян-Өндөр сумын СХС-аас 2020 онд 2 зээлдэгчийн авто тээврийн хэрэгслийг барьцаалан 25.0 сая төгрөгийн зээл олгосон боловч тээврийн хэрэгслийн гэрчилгээний эх хувийг хадгалаагүй байна.
6. Жаргалант сумын СХС-аас 2019 онд 3 хүнсний дэлгүүрт нийт 52.0 сая төгрөгийн зээл олгосон.
7. Сумдын хувьд зээл авсан иргэдийн жижиг, дунд үйлдвэр эрхлэх талаар мэдлэг, туршлагыг нотлох баримтыг шаардаагүй, гэрээний хугацаанд зээлийн эргэн төлөх боломжийг нарийн судлаагүйгээр зээл олгосон байна.

ЗГ-ын 2016 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” 153 дугаар журмын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “сумын ИТХ нь сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Гэвч 2019, 2020 онуудад Баян-Өндөр, Жаргалант сумдын ИТХ нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг шинэчлэн тогтоогоогүй байна.

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл нь зээлдэгч нарын ирүүлсэн төслийн эдийн засгийн тооцоо, судалгаа, учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоогүй, жижиг дунд үйлдвэрлэл шинээр бий болох боломж байгаа эсэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн эсэх, гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байгаа эсэх, төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байгаа эсэхийг огт харгалзаж үзэлгүй зөвхөн хурлын тэмдэглэл үйлдэн төсөл сонгон шалгаруулсан байна. Мөн зээл хэлэлцэхээс өмнө зээлийн судалгааг бодит объект дээр нь очиж судалгаа хийдэггүйгээс зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах явдал гарч байна.

1.7 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүй байна.

Аудитаар 2019, 2020 онд олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг газар дээр нь очиж үзлээ.

2020 онд Баян-Өндөр сумаас зээл авсан 21 иргэн, ААН /219.0 сая төгрөгийн/ нь зориулалтын дагуу үйл ажиллагаагаа эрхэлж, 3 зээлдэгч төслөө хэрэгжүүлээгүй, 2 зээлдэгчийн үйл ажиллагаа тогтворжоогүй байна.


Төслөө хэрэгжүүлээгүй 3 зээлдэгч:

- Жимс цагаан идээ хадгалах хөргүүр худалдан авах зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авсан иргэн. /2020/476 дугаар зээлийн гэрээ./
- Хатаасан ногооны үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар 5.0 сая төгрөгийн зээл авсан иргэн. /2020/478 дугаар зээлийн гэрээ./
- Сургуулийн нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авсан иргэн. /2020/482 дугаар зээлийн гэрээ./

Төслийн үйл ажиллагаа тогтворжоогүй 2 зээлдэгч:

- Жимсний модны тариалалт зориулалтаар 15.0 сая төгрөгийн зээл авсан аж ахуйн нэгж. /2020/466 дугаар зээлийн гэрээ./
- Ариун цэврийн цаас үйлдвэрлэл зориулалтаар 15.0 сая төгрөгийн зээл авсан аж ахуйн нэгж. /2020/480 дугаар зээлийн гэрээ./

Баян-Өндөр сумын СХС-аас 2020 онд олгосон зээлийг графикаар харуулбал:



Дээрх графикаас харахад 2020 онд зээл авсан зээлдэгчдийн 81 хувь нь зориулалтын дагуу үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, 11 хувь нь төслөө хэрэгжүүлээгүй, 8 хувийнх нь үйл ажиллагаа тогтворжоогүй байна.

2019, 2020 онд Жаргалант сумаас зээл авсан /108.5 сая төгрөгийн/ 10 иргэн, ААН нь зориулалтын дагуу үйл ажиллагаагаа эрхэлж, 1 зээлдэгч төслөө хэрэгжүүлээгүй, 2 зээлдэгчийн үйл ажиллагаа тогтворжоогүй байна.


Төслөө хэрэгжүүлээгүй 1 зээлдэгч:

- Хүнсний ногоогоор даршилсан бүтээгдэхүүн хийх зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авсан иргэн. /2019/06 дугаар зээлийн гэрээ./

Төслийн үйл ажиллагаа тогтворжоогүй 2 зээлдэгч:

- Сүү цагаан идээний үйлдвэрлэл зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авсан иргэн. /2020/01 дугаар зээлийн гэрээ./
- Модон эдлэл үйлдвэрлэл зориулалтаар 7.0 сая төгрөгийн зээл авсан иргэн. /2020/05 дугаар зээлийн гэрээ./

Жаргалант сумын СХС-аас 2019, 2020 онд олгосон зээлийг графикаар харуулбал:




Дээрх графикаас харахад 2020 онд зээл авсан зээлдэгчдийн 77 хувь нь зориулалтын дагуу үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, 8 хувь нь төслөө хэрэгжүүлээгүй, 15 хувийнх нь үйл ажиллагаа тогтворжоогүй байна.

1.8 Зээлийн гэрээний хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

ЗГ-ын 2016 оны “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих” 153 дугаар журмын 1.7-д “зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана” гэж заасны дагуу Баян-Өндөр, Жаргалант сумд зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд алданги тооцох заалтыг оруулсан байна. Гэсэн хэдий ч Жаргалант сум зээлдэгчийн зээлийг хугацаандаа төлөөгүй хоног тутмаас алданги тооцоогүй байна.

Сумдын СХС-аас зээл авсан зээлдэгчдийн тоог график, болон хүснэгтээр харуулбал:



Баян-Өндөр сумын хувьд 2020 онд 17 иргэн, 8 аж ахуй нэгжид зээл олгосон бол Жаргалант сум 7 иргэнд л зээл олгосон байна.

СХС-ийн 2020 оны 12 сарын 31-ээрх нийт авлагын үлдэгдэл, гэрээт хугацаанд төлөгдөөгүй зээлийн дүнг хүснэгтээр үзүүлбэл:

Д/д	Сумын нэр	Өмнөх он	Хорогдсон	Нэмэгдсэн	Тайлант он	Үүнээс хугацаа хэтрэлттэй
1	Баян-Өндөр сум	923,434.14	350,982.10	368,000.00	940,452.04	271,980.10
2	Жаргалант сум	230,470.00	15,327.00	0.00	215,143.00	102,930.90

Баян-Өндөр сумын СХС 2020 оны жилийн эцсийн байдлаар 271.9 сая төгрөгийн зээлийг, Жаргалант сумын СХС 102.9 сая төгрөгийн зээлийг гэрээт хугацаанд төлүүлээгүй, гэрээний үүргийг биелүүлээгүй байна.

Дээрх 374.8 сая төгрөгийн 2 зөрчилд холбогдох албан тушаалтнуудад албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ ХЭДИЙ Ч ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА.

2.1 Сумдын ИТХ-аас томилсон орон тооны бус хяналтын зөвлөлүүд журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 3.3.2-т “сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчээр ахлуулан, Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;” гэж заасан. Үүний дагуу Баян-Өндөр болон Жаргалант сум орон тооны бус зөвлөлөө байгуулахдаа хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн ИНХ-аар хэлэлцэн сонгосон байхаар журамд заасан байтал гишүүдийг ихэнх багууд ИНХ-аар хэлэлцүүлдэггүй, сумын ИТХ-ын тогтоолоор томилсон байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тушаалын “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3.1², 5.3.2³ дахь заалтад заасны дагуу хяналтын зөвлөл нь сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахаар байтал сумдын хяналтын зөвлөл нь сангийн үйл ажиллагаанд улирал тутам хяналт шалгалт хийгээгүй, жилд нэг удаа зээлдэгчдийн үйл ажиллагаанд л хяналт шалгалт хийсэн байна.

Тухайн жилдээ ганц удаа хийсэн хяналт шалгалтын тайлангаа иргэдэд мэдээлээгүй, сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна. Мөн зээл авсан иргэн, ААН-ийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайлан гаргуулан аваагүй байна.

2.2 Сангийн зарцуулалтад хийсэн аудитаар өмнөх онуудад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.

2018 онд хийгдсэн “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Мөн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Сангаас олгосон зээлийн холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

² зээл авсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулан авах;

³ сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;

СХС-ийн хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдийн мэдээлэл Монгол банкны мэдээллийн санд орсноор бусад эх үүсвэрээс давхар зээл авсан, найдваргүй зээлдэгчийн судалгаа гарч чанаргүй зээлдэгч нарт дахин зээл олгохгүй байх асуудлыг шийдвэрлэх боломж бий болсон байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд заасны дагуу төлөвлөх шаардлагатай байна.
- Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй байна.
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулаагүй байна.
- Зээлийн гэрээний хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.
- Сумдын ИТХ-аас томилсон орон тооны бус хяналтын зөвлөлүүд журамд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Сангийн зарцуулалтад хийсэн аудитаар өмнөх онуудад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**Баян-Өндөр сумын Засаг дарга Б.Баасансүрэнд:**


- СХС-ийн тухайн жилийн зээлийн үндсэн төлбөр, хүүгийн орлогыг төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулах.
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллах.
- Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2020 онд зээл аваад Төслөө одоог хүртэл хэрэгжүүлээгүй 3 зээлдэгчийн гэрээг цуцлах.

Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаярт:

- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг мөрдөж ажиллах.
- 2020 онд зээл аваад төслөө одоог хүртэл хэрэгжүүлээгүй 1 зээлдэгчийн гэрээг цуцлах.

ТАЙЛАН БИЧСЭН:

Ахлах аудитор:  Б.Буян-Ундрах

Аудитор:  Д.Цогбадрах

6117143690
04A0073 9042806

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ОРХОН АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГА


61025 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Окуут баг
III Отгонбүлгийн гудамж
Утас: 70357965, Факс: 70350965
Цахим хаяг: www.bayandor.mn
Цахим шуудан: buzdg@gmail.com

№ 11571

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу “Сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны зээлийн олголт үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийгдсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Саналыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдье.



ЗАСАГ ДАРГА Б.БААСАНСҮРЭН

Ф.Буян-Уурагч
Тайлангийн дэсвийн
хүснэгт танилцуулах.
МЭ 2020.01.15
ХН/20
D:/My Documents/ A-5. doc

ОРХОН АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

61010 Орхон аймаг, Жаргалант сум, Жаргалант баг
Нутгийн удирдлагын ордон Утас: 70397203
Цахим хуудас: www.erdenet.mn

№ 624

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн 2019, 2020 оны гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэд саналгүй болно.



ЗАСАГ ДАРГА Б.ЗОРИГТБАЯР

Ф.Буян-Уурагч
Тайланг хүлээн.
МЭ 2020.01.15
ХН/20
0000000800

D: Албан ёсоор А-5